



АРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/35

Эрдэнэбулган сум

Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн
үнэлгээний баг томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын тамгын газрын төрийн албан хаагчдын 2024 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Багийн ахлагч:

А.Батболд

(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Ж.Мөнхбат

(Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Б.Лхагвасүрэн

(Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)

И.Амартүвшин

(Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Б.Наранчимэг

(Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Ж.Ганбаатар

(Цэргийн штабын дарга, хурандаа)

М.Оюунцэцэг

(Төрийн албан хаагчийн төлөөлөл)

Нарийн бичиг:

Г.Оюунсаран

(Хүний нөөцийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн)

2.Албан хаагчдын төлөвлөгөөний биелэлтийг үнэлж, баталгаажуулан Үнэлгээний багт 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн дотор хүргүүлэхийг нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Албан хаагчдын 2024 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэхдээ батлагдсан аргачлалын дагуу, нотолгоонд суурилсан, шударга, ил тод байх зарчмыг баримтлан ажиллаж, дүнг 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн дотор баталгаажуулах, үнэлгээний мөрөөр авах арга хэмжээний санал танилцуулахыг үнэлгээний баг (А.Батболд)-т даалгасугай.